

**“СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨР, АМЬЖИРГААНЫ ЗАРДАЛД  
ЗОРИУЛАН ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ, ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ  
ЗЭЭЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН ОРОЛЦООТОЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ,  
ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, СУРГАЛТЫН ЗЭЭЛИЙГ ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ,  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах асуудал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг болон Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэсэн болно.

**ХОЁР. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн тогтоолын төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм. Иймд тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх болон тогтоолын төслөөр тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Практикт хэрэгжих боломж:**

Тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгагдсан суралцагчдад зээл олгохтой холбоотой харилцаанд баримтлах зарчим, ажиллах журмыг тогтооно.

Суралцагчид олгох зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зээлийн хэмжээг тогтоох, эргэн төлүүлэх, хөнгөлөх, чөлөөлөх, үйл ажиллагааны удирдлагын зарчим тодорхойлох журмыг тогтооно.

Зээлийн санхүүжилтийг олгох болон Засгийн газар, Засгийн газрын гишүүн, Боловсролын зээлийн сангийн удирдах зөвлөл тэдгээрийн эрх, үүргийг нарийвчлан тусгана. Эдгээр зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

➤ Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар тогтоолын төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Харилцан уялдаа:

Тогтоолын төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилгүй байх шаардлагатай.

Иймд тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

2012 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль батлагдсанаар суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтоохоор хуульчилсан бөгөөд уг журам өнөөг хүртэл батлагдаагүй байна. Энэ нь дотоод, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцуулах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал болоод байна.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль 2011 онд батлагдахаас өмнө дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч хагас өнчин, малчин өрхийн, нэн ядуу өрхийн гишүүн,

нийгмийн бусад зорилтот бүлгийн иргэдэд сургалтын төлбөрийн зээл олгож, төрийн байгууллагад ажилласан жилийг харгалзан Засгийн газар чөлөөлдөг зохицуулалттай байсан.

Иймд тогтоолын төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийсэн тул "зардал тооцох" шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

## ГУРАВ. ТОГТООЛЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

### 1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн тогтоолын төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдаж, 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийн 8.8 дахь хэсэгт "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно." хэмээн заасны тогтоолын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Засгийн газрын 2004 оны "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 22 дугаар тогтоол, 2008 оны "Зарим хүмүүсийг сургалтын төрийн сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай" 178 дугаар тогтоол, 2009 оны "Зарим хүмүүсийг сургалтын төрийн сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай" 242 дугаар тогтоолоор тус тус гадаад, дотоодод зээлээр суралцагчдын зээлийг чөлөөлсөн. Үүнээс хойш зээлийг чөлөөлөхтэй холбоотой тогтоол шийдвэр гараагүй байна.

Засгийн газрын тогтоолоор баталсан зээлээр суралцуулах журам болон суралцагчтай байгуулсан гэрээнд ажилласан жилийг харгалзан зээлийн

төлбөрөөс чөлөөлөх зохицуулалттай байсан ч хуулийг хэрэгжүүлээгүйн улмаас суралцагчид гэрээний үүргээ биелүүлсэн зээлээс чөлөөлөгдөж чадхгүй нөхцөл байдал үүсээд байна.

## 2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Тогтоолын төслийн зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилгоор холбогдох байгууллагуудын статистик мэдээ, тогтоолын төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

Суралцагчид зээл олгох үйл ажиллагаанд хэрэгжиж байсан нийтлэг зохицуулалтыг болон үйл ажиллагаанд зохицуулах шаардлагатай болсон зарим зохицуулалтыг тусгаж, шийдвэрлэсэн тул практикт хэрэгжих боломжтой байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг байгууллага /Боловсролын зээлийн сан/-ын саналыг авч тогтоолын төсөл боловсруулсан тул практикт турших шаардлагагүй хэмээн үзсэн.

## 3. Ойлгомжтой байдлыг шалгах:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тогтоолын төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам нь нийтлэг үндэслэл, сургалтын зээлийн санхүүгийн эх үүсвэр, зээлийн хэмжээг тогтоох, зээлийн эргэн төлөлт, зээлээс хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох, бусад гэсэн 6 бүлэг бүхий байна.

Тогтоолын төсөлд тусгагдсан харилцаанд Засгийн газар, Засгийн газрын гишүүн, Боловсролын зээлийн сан, түүний удирдах зөвлөл, суралцагчийн эрх үүргийг тодорхой тусгаж, хэл найруулгын шаардлагыг хангасан болно.

Тогтоолын төсөл нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

## 4. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг аргачлалд тусгасан тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад

хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчил байхгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Тогтоолын төсөл нь бусад хуулийн заалтыг давхардуулаагүй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах тогтоолын төслийг боловсруулсан байх	Бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Тогтоолын төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Тогтоолын төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Тогтоолын төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.

3	Тогтоолын төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн тогтоолын төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Бусад хуулийн нэр томьёотой нийцсэн байна.
4	Тогтоолын төслийн зүйл, заалт тухайн тогтоолын төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Тогтоолын төсөл нь бусад хуулийн заалттай нийцэж байна.
5	Тогтоолын төслийн зүйл, заалт тухайн тогтоолын төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Тогтоолын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Тогтоолын төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх, үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Тогтоолын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд оруулах шаардлагатай орхигдуулсан зохицуулалт байхгүй байна.
8	Тогтоолын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй	Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөллыг оруулахаар тусгаж өгсөн.
10	Татварын хуулиас бусад тогтоолын төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Татвар, төлбөр, хураамж зохицуулалт агуулаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.

12	Тогтоолын төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Тогтоолын төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, ялгаварласан зохицуулалт агуулаагүй.
13	Тогтоолын төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Холбоотой заалт тусгагдаагүй байна.
14	Тогтоолын төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Санхүүгийн дэмжлэгийг ил тод, нээлттэй байлгах тул давуу талтай хэмээн дүгнэж байна.
15	Тогтоолын төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд тогтоолын төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

#### ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү тогтоолын төсөл, хууль тогтоомжийг үнэлэх явцад сөрөг үр нөлөө тогтоогдоогүй болно.

--- оОо ---

**“СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨР, АМЬЖИРГААНЫ ЗАРДАЛД  
 ЗОРИУЛАН ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ, ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ  
 ЗЭЭЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН ОРОЛЦООТОЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ,  
 ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, СУРГАЛТЫН ЗЭЭЛИЙГ ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ,  
 ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
 ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэх холбоотой гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсратаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй, харин хуулийн этгээд болон төрийн байгууллагад зардал үүсэхээр зохицуулагдсан байна. Иймд тогтоолын төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх хуулийн этгээд болон төрийн байгууллагад үүсэх зардлыг буюу зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх судалгааг тоймлон гаргалаа.

Гадаад орны дээд боловсролын байгууллагад суралцагчдын зээл

Хүснэгт-1

Д/д	Боловсролын зээлийн сангийн санхүүжилт /хөтөлбөр/	Суралцах хугацаа /жил/	Жилд авах санхүүжилт /ам. доллар/	Нийт авах санхүүжилт	Жилд оногдох төлөлт /15 жил/	Сард
1	Магистр	2	16 000	32 000 ам. доллар /32000* 2738.92 = 87.645 сая	5.8 сая	487 мянга
2	Доктор	3	16 000	48 000 ам. доллар /48000*2738.92=131.468 сая/	8.8 сая	730 мянга

3	Дэлхийн шилдэг бакалаврын хөтөлбөр	4	29 000	29 000 ам. доллар / 116000*2738,92= 317.714 сая/	21,2 сая	1 сая 800 мянга
---	------------------------------------	---	--------	--	----------	-----------------

Гадаадад суралцсан иргэд нь эх орондоо 5 жил ажилласан тохиолдолд зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөгдөнө.

Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын зээл

Хүснэгт-2

Д/д	Боловсролын зээлийн сангийн санхүүжилт /хөтөлбөр/	Суралцах хугацаа /жил/	1 жилийн сургалтын төлбөр төгрөгөөр / сүүлийн 3 жилийн дундаж /	Нийт авах санхүүжилт	Жилд оногдох төлөлт /10 жил/	Сард
1	Бакалавр	4	2 сая 200 мянга	8 сая 800 мянга	880 мянга	73 мянга
2	Магистр	2	3 сая 300 мянга	6 сая 600 мянга	660 мянга	55 мянга
3	Доктор	3	4 сая 600 мянга	13 сая 800 мянга	1 сая 380 мянга	115 мянга

Дотоодод суралцсан иргэд нь эх орондоо 3 жил ажилласан тохиолдолд 50 хувь хөнгөлж, 5 жил ажилласан тохиолдолд зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөгдөнө.

Гадаадад суралцагчдын зээлийг чөлөөлсөн судалгаа

Хүснэгт-3

Д/д	Зээлийн чөлөөлөлт	Огноо	Чөлөөлөгдсөн иргэдийн тоо	Зээлийн хэмжээ /ам.доллар/
1	ЗГ-ын 2008 оны 178 дугаар тогтоол	2008.05.14	50	930,168.60
2	ЗГ-ын 2009 оны 242 дугаар тогтоол	2009.08.06	61	1,635,469.00
3	БШУСайдын 2013 оны А/185	2013.05.22	199	5,078,024.90
4	БШУСайдын 2013 оны А/475	2013.12.27	1	8,000.00
5	БШУСайдын 2014 оны А/107	2014.03.24	105	2,938,348.60
6	БШУСайдын 2014 оны А/212	2014.05.15	7	140,978.00
7	БШУСайдын 2014 оны А/459	2014.11.25	25	692,697.67
8	БСШУСайдын 2015 оны А/264	2015.07.01	49	1,387,895.68
9	БСШУСайдын 2016 оны А/260	2016.06.23	51	1,369,120.48
10	БСШУССайдын 2017 оны А/88	2017.07.27	51	1,376,814.00
11	БСШУССайдын 2018 оны А/555	2018.08.31	74	1,829,371.00
12	БСШУССайдын 2018\9 оны А/658	2019.10.18	71	2,258,306.38
Нийт			744	19,645,194.31

Дотоодод суралцагчдын зээлийн чөлөөлсөн судалгаа

Хүснэгт-4

Д/д	Зээлийн чөлөөлөлт	Огноо	Чөлөөлөгдсөн иргэдийн тоо	Зээлийн хэмжээ
1	ЗГ-ын 2004 оны 22 дугаар тогтоол	2004.01.29	23,038	8,200,000,000.0
2	ЗГ-ын 2008 оны 178 дугаар тогтоол	2008.05.14	2,982	2,921,836,600.0
Нийт		-	26,020	11,121,836,600.0

Боловсролын зээлийн санд диплом нь хадгалагдаж буй дотоодод суралцагчдын судалгаа

Хүснэгт-5

№	Төгссөн он	Суралцагчдын тоо	Зээлийн хэмжээ /мян.төг/
1	2004	1180	1,181,975.0
2	2005	740	734,466.2
3	2006	847	862,055.3
4	2007	1224	1,271,789.4
5	2008	1887	2,013,196.6
6	2009	1470	1,669,714.7
7	2010	1243	1,542,197.0
8	2011	1179	1,475,431.9
9	2012	1285	1,587,391.5
10	2013	1247	1,338,253.5
11	2014	881	889,580.7
12	2015	643	726,940.2
13	2016	587	741,670.6
Нийт		14413	16,034,662.6

--- оОо ---



### УИХ тогтоолын төсөлд авах тухай

МОНГОЛ | ЛСЫН ИХ ХУРЫЛЫН ТОГТООЛ

2020 ОНЫ ДУГААР САРЫН 15-ӨДӨӨ

МОНГОЛ

Улаанбаатар хот

Журам баглаах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцлагачдын нийгмийн агаарзаны тухай хуулийн 5-д заасныг үндэслэн Монгол улсын Их Хурлаас тогтоох нь

1. Суралцлагачдын сургалтын төлбөр амьчиргалтын зардал зөрчлөлтийг олгох төлөвтэй эргэн төлөлдөг нөхцөлтэй зардалын төлбөр, суралцлагачдын нийгмийн агаарзаны төлбөр, эргэн төлүүлэх, сургалтын зардалыг өмнөдөх чөлөөлөл, хүчинсүй бэлтгэл журам-ыг гавсраат ёсоор баталсуурь.

2. Журын хэрэглээг багтгал эхлэх, хэрэгжлэлтэй эргэн төлүүлэх журын хэрэглээг багтгал тавих ажиллагааг Аж-оог улсын Засгийн газар (УХЗ) бүрэлдэхүүнд багасгуулах

УИХ тогтоолын төсөлд авах тухай

ЕРВНХИЙ БОЛОВСРОЛЫН

ОНЦЛОХ МЭДЭЭ



СУБЖИЙН

ХАА УУЛИСАН

УИХ тогтоолын төсөлд авах тухай

ЕРВНХИЙ БОЛОВСРОЛЫН

### ЕРӨНДИЙ БОЛОВСРОЛЫН СУРУУЛИЙН УДИРШАГА.

### "Монгол Улсын үндэстний цөмийн үүсгэлийн лос зөвлөл"

### "Ерөмдэй Боловсролын салбарын чиглэлээр 2019 онд"

### Төлө хөгжлийн үргэлжлүүлэн зөвлөм бэйгууна

### ОНЦЛОХ ВИДЕО



УИХ-ийн нэгдсэн чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар ВКХЗУ-д дэргэдэн цана



УРСЫН ИХ ХУРЫН ДАРГА

Г.ЗАНДОРЖИДАТ


Тусгаар тогтоолын хэргийг

Урсдын Их Хурлын 2020 оны

СУРАЛЦАГЧИЙН СУРАЛТЫН ТӨЛБӨР АМЬЖИРГААНЫ ЗАРДАЛД ЗӨГИЙЛҮГЭЛГЭХ ХӨНГӨРӨЛТӨЙ ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛГЭН ЗЭЭЛИЙН УРСЫН ТӨСВИЙН ОРЛОЦООГООЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ ЭРГЭН ТӨЛӨҮЛЭХ СУРАЛТЫН ЗЭЭЛИЙГ ХӨНГӨЛӨХ ЧӨЛӨӨЛӨХ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХУРАМ

НЭГ Нийтлэх үндэстэн

1.1 Монгол Улсын болон гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурагчдын сургалтын төлбөр амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авах "Сургалтын зээл" гэрээний үндсэн дээр олгогдох эргэн төлөгдөх зээлийн сургалтын зээлийг эргэн төлүүлэх чөлөөтэй үнэмлэхүй болгох зэрэг арга хэрэгсэл



1.2 Энэхүү журмыг нь Монгол улсын болон гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад Засгийн газраас баталсан журмын дагуу бакалавр шилжлэг дэргэдүн боловсролыг эзэмшмээр элсэх зорилготой хөшөөн дагуу Боловсролын Засгийн газраас сургалтын зээл авсан Монгол Улсын иргэнд хамарна

1.3 Энэхүү журмын дагуу зээл огтоосон суралцагчийн сургалтын зээлийг төлөхөд, төрөлөөр, сүүнхгүй болгох асуудлыг Засгийн газар хариуцаж, хамгаална

1.4 Суралцагчийн сургалтын зээлийн мэдээллийг Монгол улсын засгийн мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагайг Боловсролын Засгийн газар хариуцаж зохион байгуулна

**ХОЁР. Сургалтын зээлийн санхүүгийн зх үүсвэр**

- 2.1 Суралцагчид өгөх сургалтын зээл нь Засгийн газрын тусгай сангийн тусгай хурлын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан зх үүсвэрээс бүтэнэ
- 2.2 Сургалтын зээлд шаардагдан ирэхгүй жил бүр улсын төсөвт тусгана
- 2.3 Гадаадад суралцагчид өгөхөд барилгалах зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал зөвлөсөн төрийн захиргааны төв байгууллагын сондрогоор санхүүг харгалзан Засгийн газар тусгай улсын иргэдийн амьжиргааны тусалгатай үйлдвэрийн өсгөвөр хөндөгчид жил бүр тусгана
- 2.4 Гадаадад суралцагчийн сургалтын зээлийг суралцагчид буй сургууль нь нэгжлэгээр хичээлийн бэлд цэгийн төлбөр, зүүн хэмжээний даатгал гадаад суралцагчийн зураглас, нөхөн сангийн үйлдвэрийн төлбөр зурдагчид өргүүлж тооцно

**Г. ГЭВ. Зээлийн зөвхөн төлөлт**

- 3.1 Суралцагчид эхлүү журмын дагуу агаарас баталсан журмын дагуу сургалтын зээл өгнө
- 3.2 Суралцагч нь Боловсролын зээлийн сан-ын сургалтын зээлийн гэрээ байгуулна
- 3.3 Энэ журмын 2.1 заасан сургалтын зээлийн гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал зөвлөсөн Засгийн газрын нийгмийн хэлтсийн байрлал
- 3.4 Боловсролын зээлийн сан нь суралцагчийг байгуулсан гэрээний хариуцагчид хариуцаж, зээлийг тогтоосон хугацаанд зөвхөн төлүүлж, аарсныг тусгай төсөвт төлбөрүүлнэ
- 3.5 Сургалтын зээлээр суралцагч сургуульд төлсөний дараа Боловсролын зээлийн санд заавал бүртгүүлнэ
- 3.6 Сургалтын зээлд суралцагч төлсөн тогтоосон хугацаанд бүртгүүлсэний тохиолдолд төрлүүл төлөх бөгөөд төрлүүлний хэмжээг энэ журмын 2.1 заасан гэрээнд тусгана

3.7 Төрлүүл, агаарын үнэ, зээл үнэ, өрчлөх өртөг, зүүн хэмжээ, төсвийн журмын дагуу зөвлөсөн Засгийн газар хариуцаж тооцно

